



МОНГОЛ УЛС  
ДУНГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 09 сарын 22 өдөр

Дугаар 1316

Мандалговь

Бага наадам зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5/а/, Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.6, Соёлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.8, 16.1.12 дахь заалт, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.3 дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2017 оны 12 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Олон Улсын Ахмадын баярыг тохиолдуулан аймгийн Ахмадын урлагийн V бага наадмыг 2017 оны 10 дугаар сард багтаан зохион байгуулсугай.

Хоёр. Бага наадмын зохион байгуулах зардлыг хавсралтаар баталсугай.

Гурав. Ахмадын урлагийн наадмын шагналд 1770000 /Нэг сая долоон зуун далан мянга/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн ЗДТГ-ын дарга /Ц.Эрдэнэсүрэн/, нягтлан бодогч /Ц.Даваа/ нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

0200880